



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 78

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2011 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 226 дугаар тогтоол, "Журам батлах тухай" Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 37 дугаар тогтоол, "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 323 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЧИНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

Засгийн газрын 2024 оны 02 дугаар
сарын 28-ны өдрийн 78 дугаар
тогтоолын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАРЦУУЛАХ, ХЯНАЛТ
ТАВИХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан Эрүүл мэндийг дэмжих сан (цаашид "Сан" гэх)-ийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, түүнд хяналт тавихад энэ журмыг баримтална.

1.2.Сан нь үйл ажиллагаандаа Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Донорын тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон энэ журмыг баримтална.

1.3.Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хариуцан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан журмын дагуу хяналт тавьж, тайлагнана.

Хоёр.Сангийн хөрөнгийг төвлөрүүлэх

2.1.Сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22.1-д заасны дагуу Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулна.

2.2.Сангийн хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

2.2.1.улсын төсвийн хөрөнгө;

2.2.2.хандив, тусламж;

2.2.3.архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь;

2.2.4.эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь;

2.2.5.тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө.

Гурав.Сангийн хөрөнгийг зарцуулах

3.1.Сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19.3-т заасан дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

3.1.1.иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэнд эрүүл зан үйл төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа;

3.1.2.хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг судлах, тандах үйл ажиллагаа;

3.1.3.эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах үйл ажиллагаа;

3.1.4.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх үйл ажиллагаа;

3.1.5.зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн үйлчлүүлэгчийн эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх;

3.1.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 8.1-д заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хангаагүй, эсхүл төлж байгаагүй амьгүй донорын гэр бүлийн гишүүнд олгох нэг удаагийн тэтгэмжийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан жишиг тарифыг баримтлан нэг удаа олгох.

3.2.Эрүүл мэндийг дэмжих сангийн жилийн төсвийн хуваарийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3.3.Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг бүртгэх, сонгон шалгаруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ.

3.4.Сангийн хөрөнгөөс аливаа татаас, урамшуулал, тусламж олгох, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.

Дөрөв.Нийгмийн эрүүл мэндийн төсөл, арга хэмжээг Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх

4.1.Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх энэ журмын 3.1.1-3.1.3-т заасан арга хэмжээний тэргүүлэх чиглэлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохицуулалтын чиг үүрэг хариуцсан нэгж боловсруулж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн жил бүр батална.

4.2.Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний санал нь энэ журмын 4.1-д заасан чиглэлээс гадна дараах шаардлагад нийцсэн байна:

4.2.1.төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр дэвшүүлсэн зорилтод нийцсэн байх;

4.2.2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр дэвшүүлсэн зорилтод нийцсэн байх;

4.2.3.эрүүл мэндийн салбарын бодлогын уялдааг хангасан тодорхой хэрэгжих боломжтой, хүрэх үр дүнг бодитой тооцсон байх;

4.2.4.төсөл хэрэгжүүлэгчийн хүний нөөц, санхүүгийн чадавхын талаарх мэдээллийг хавсаргасан байх;

4.2.5.төслийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, санхүүгийн тооцооллыг хийсэн байх.

4.3.Энэ журмын 3.1.1-3.1.3-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв жилд 1 удаа зохион байгуулна.

4.4.Нийгмийн эрүүл мэндийн тэргүүлэх чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлэх хуулийн этгээдийн нээлттэй сонгон шалгаруулалтыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулж, дүнг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

4.5.Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах Ажлын хэсгийн гуравны нэгээс доошгүй нь төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо болон холбогдох салбар зөвлөлийн төлөөлөл байхаар зохион байгуулна.

4.6.Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв нь Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтын талаар ажлын 10-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

4.7.Хуулийн этгээд нь Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүсэлтийг сонгон шалгаруулалт зарлагдсанаас хойш ажлын 21 хоногийн дотор Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд албан бичгээр ирүүлнэ.

4.8.Сонгон шалгаруулалтын Ажлын хэсэг энэ журмын 4.7-д заасны дагуу ирүүлсэн төсөл, арга хэмжээг хянан үзэж, мөн журмын 4.2-т заасан шаардлагад нийцсэн төсөл, арга хэмжээг шалгаруулж, шийдвэрээ эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.9.Сонгон шалгаруулалтын Ажлын хэсгийн шийдвэрийг үндэслэн шалгарсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хуулийн этгээдэд санхүүжилт олгох тушаалыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.10.Шалгарсан төсөл, арга хэмжээг ажлын 5 хоногт багтаан Ажлын хэсэг нийтэд ил, тод нээлттэй мэдээлнэ.

4.11.Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг дараах хэлбэрээр олгоно:

4.11.1.урьдчилгаа олгож гүйцэтгэлээр санхүүжүүлэх буюу тухайн ажил, үйлчилгээний онцлог, шаардагдах хөрөнгийн хэмжээтэй уялдуулан үе шаттайгаар санхүүжүүлэх;

4.11.2.төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж энэ журмын 4.12-т заасан гэрээг дүгнэн үлдэгдэл санхүүжилт олгох;

4.11.3.ажил, үйлчилгээг гүйцэтгэсний дараа санхүүжилтийг бүрэн хэмжээгээр нэг удаа олгох.

4.12.Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина. Гэрээнд дараах зүйлийг заавал тусгана:

4.12.1.ажлын даалгавар;

4.12.2.сангаас санхүүжилт олгох хэлбэр болон хуваарь;

4.12.3.санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан ирүүлэх хугацаа.

Тав.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн
дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх
үйл ажиллагааг Сангийн хөрөнгөөр
санхүүжүүлэх

5.1.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх арга хэмжээ гэдэгт Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3.1.1-д заасан үйл ажиллагааг багтаана.

5.2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохицуулалтын чиг үүрэг хариуцсан нэгж боловсруулж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн жил бүр батална.

5.3.Энэ журмын 3.1.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөлөл оролцсон Ажлын хэсэг жилд 1 удаа зохион байгуулна.

5.4.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх төсөл шалгаруулахад дараах чиглэл баримтална:

5.4.1.Монгол Улсад оношлогдож, эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийг оношлох, эмчлэх чадавхыг бүрдүүлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, шинэ арга, аргачлал нэвтрүүлэх;

5.4.2.Монгол Улсад оношлогдож, эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийг оношлох, эмчлэх хүний нөөцийн чадавх бэхжүүлэх зорилгоор эмнэлгийн мэргэжилтнийг гадаад улс оронд сургах;

5.4.3.гадаад улс орны эмнэлгийн мэргэжилтнийг урьж ажиллуулан, дотоодын эмч нарт ажлын байрны сургалт зохион байгуулах;

5.4.4.орон нутагт оношилж, эмчлэх боломжгүй өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, эмнэлгийн мэргэжилтний чадавхыг бэхжүүлэх, технологи нутагшуулах зорилгоор төрөлжсөн мэргэшлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнг багаар нь орон нутагт ажиллуулах, инновацад шаардлагатай зарим техник, тоног төхөөрөмжөөр хангах;

5.4.5.дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, нутагшуулах явцад хийгдсэн оношилгоо, эмчилгээний зардлыг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

5.5.Төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтад оролцогч нь дараах төрийн болон хувийн хэвшлийн хуулийн этгээд байна:

5.5.1.төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг;

5.5.2. нэгдсэн эмнэлэг.

5.6. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулна.

5.7. Ажлын хэсэг нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээд, судалгааны багийн нээлттэй сонгон шалгаруулалтыг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулж, дүнг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

5.8. Ажлын хэсэг нь Сангийн хөрөнгөөр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх сонгон шалгаруулалтын талаар ажлын 15 хоногийн өмнө хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

5.9. Хуулийн этгээд нь Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн хүсэлтээ сонгон шалгаруулалт зарлагдсанаас хойш ажлын 21 хоногийн дотор эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр ирүүлнэ.

5.10. Сонгон шалгаруулалтын Ажлын хэсэг ирсэн төслийг хянан үзэж энэ журмын 5.4-т заасан чиглэлийг баримталсан, 5.5-д заасан хуулийн этгээдийн төслийг санхүүжүүлэх эсэхийг хэлэлцэж шийдвэрээ эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөлд хүргүүлнэ.

5.11. Шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас мэргэжлийн шинжээч томилж, эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн төсөлд нэмэлт дүгнэлт гаргуулж болно.

5.12. Шинжлэх ухаан, технологийн зөвлөл Ажлын хэсгээс ирүүлсэн шийдвэрийг ажлын 10 хоногт багтаан хянан хэлэлцэж эцэслэн шийдвэрлэнэ.

5.13. Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн Ажлын хэсэг шалгарсан төслийг ажлын 5 хоногт багтаан нийтэд мэдээлнэ.

5.14. Сангийн хөрөнгөөр төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдтэй эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Гэрээнд дараах зүйлийг заавал тусгана:

5.14.1. төсөл дууссаны дараа хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон үндсэн хөрөнгийн эзэмшлийн талаар тусгах;

5.14.2. төсөл хэрэгжүүлэх хугацаа;

5.14.3. үйл ажиллагааны явцын тайлан ирүүлэх хугацаа;

5.14.4. сангаас санхүүжилт олгох хэлбэр болон хуваарь;

5.14.5. санхүүгийн тайлан ирүүлэх хугацаа;

5.14.6. ажлын үр дүн, гүйцэтгэлийн тайлан ирүүлэх хугацаа.

5.15.Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн үр дүнг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх тухайн чиглэлийн мэргэжлийн салбар зөвлөл хэлэлцэж, дүгнэлт гаргасан байна.

**Зургаа.Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх
үйлчлүүлэгчид Сангийн хөрөнгөөр дэмжлэг үзүүлэх**

6.1.Энэ журмын 3.1.5-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчнөөр гадаад улсад эмчлүүлсэн үйлчлүүлэгчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх) зохион байгуулна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.2.Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалтыг хоёр жил тутамд шинэчилж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.3.Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн үйлчлүүлэгч эмчилгээний сүүлийн өдрөөс хойш 3 сарын дотор санхүүгийн дэмжлэг хүссэн хүсэлтээ, нотлох баримтын хамт эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана:

6.3.1.иргэний үнэмлэх (хүүхэд бол төрсний гэрчилгээ)-ийн хуулбар;

6.3.2.Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчнөөр гадаад улсад эмчлүүлэх шаардлагатайг эмчлүүлэхээс өмнө тодорхойлсон төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн гадаад эмчилгээний комиссын дүгнэлт эх хувиар;

6.3.3.гадаад улсад эмчилгээнд хамрагдсан эмнэлгийн дүгнэлт, төлбөр төлсөн баримт эх хувиар;

6.3.4.насанд хүрэгчид нь сүүлийн 5-аас доошгүй жил эрүүл мэндийн даатгалд тасралтгүй даатгуулсныг нотлох баримт.

6.4.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохицуулалтын чиг үүрэг хариуцсан нэгж нь Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчнөөр гадаад улсад эмчлүүлсэн үйлчлүүлэгчийн хүсэлтийг хүлээн авч судлан, саналаа Зөвлөлийн хуралд танилцуулна.

6.4.1.Зөвлөл 2 сар тутам хуралдаж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх эсэх талаар шийдвэр гаргана;

6.4.2.Зөвлөлийн хурлын шийдвэрийг ажлын 5 хоногийн дотор Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталгаажуулж, ажлын 7 хоногийн дотор Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлнэ;

6.4.3.Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчнөөр гадаад улсад эмчлүүлсэн 18 ба түүнээс дээш насны иргэнд эмчилгээний төлбөрийн 20 хувийг, 0-18 хүртэлх насны хүүхдэд эмчилгээний төлбөрийн 50 хувийг олгоно.

6.5.Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн гадаад эмчилгээний комиссын дүгнэлтгүйгээр гадаад улсад эмчлүүлсэн, Зөвлөлийн шийдвэр гарахаас өмнө нас барсан тохиолдолд санхүүгийн дэмжлэгийг нөхөн олгохгүй.

6.6.Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчнөөр гадаад улсад эмчлүүлэхээр явж байгаа үйлчлүүлэгчийн тээвэр, байр, хоол, дагалдан явах хүний зардлыг санхүүжүүлэхгүй.

6.7.Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчилгээнд хамрагдсан төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 59.1.7-д заасан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын дагуу дэмжлэг үзүүлнэ.

6.8.Энэ журмын 6.7-д заасан дэмжлэг авсан иргэнд гадаад улсад эмчлүүлэх зориулалтаар зардал Сангийн хөрөнгөөс давхардуулан олгохгүй.

Долоо.Амьгүй донорын гэр бүлийн гишүүнд олгох нэг удаагийн тэтгэмжийг Сангийн хөрөнгөөс олгох

7.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 8.1-д заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хангаагүй, эсхүл төлж байгаагүй амьгүй донорт олгох тэтгэмжийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 8.3-т заасан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан жишиг тарифыг баримтлан гэр бүлийн гишүүнд нэг удаагийн тэтгэмж олгоно.

7.2.Амьгүй донорт нэг удаагийн тэтгэмж олгохдоо “Амьгүй донор” болсон талаарх тухайн эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

Найм.Сангийн хөрөнгийн зарцуулалтыг тайлагнах, хянах

8.1.Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний тайланг хуулийн этгээд тухайн жилийн санхүүгийн тайлангийн хугацааг баримтлан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

8.2.Сангийн тайлан, хөрөнгийн зарцуулалтад Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн Тавдугаар бүлэгт заасны дагуу хяналт тавьж, тайлагнана.

8.3.Сангийн зарцуулалтын жилийн эцсийн тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлтийн хамт уг тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор байгууллагын цахим хуудас болон шилэн дансанд байршуулна.

8.4.Сангийн орлого, зарлагын тайланг харьяалах татварын албанд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв тайлагнана.

8.5.Сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжилт авсан төсөл, арга хэмжээний мэдээллийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.2-т заасны дагуу олон нийтэд мэдээлж, тогтмол шинэчилнэ.

8.6.Сангийн яаманд хагас, бүтэн жилээр тайлагнана.

Ес.Бусад

9.1.Сангийн хөрөнгийг бусдад хандивлах, барьцаалах, зориулалтын бусаар зарцуулах, зээлээр ашиглах, ашиглуулах аливаа үйл ажиллагааг хориглоно.

9.2.Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.3.Сангийн эх үүсвэрээр төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх шийдвэр гаргах албан тушаалтан нь холбогдох хуульд заасан журмын дагуу ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

9.4.Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөлд шинээр бүтээх эм, биологийн идэвхт бодис, оношлуур, урвалж, тоног төхөөрөмж, ховор өвчин хамаарахгүй.

9.5.Сангийн хөрөнгөөс санхүүжилт авахаар баримт, материалыг хуурамчаар бүрдүүлж шийдвэр гаргуулсан этгээдээр олгосон төлбөрийг нөхөн төлүүлэх асуудлыг зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

----o0o----

